



Аудит, Эрсдэлийн Хорооны журам

2023 он

Агуулга

1. Нийтлэг үндэслэл
2. Аудит, Эрсдэлийн Хорооны зорилго, чиг үүрэг
3. Аудит, Эрсдэлийн Хорооны бүтэц, бүрэлдэхүүн
4. Аудит, Эрсдэлийн Хорооны хурал
5. Аудит, Эрсдэлийн Хорооны Бүрэн эрх
6. Аудит, Эрсдэлийн Хорооны үүрэг, хариуцлага
7. Ажлын тайлан

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ АУДИТ, ЭРСДЭЛИЙН ХОРООНЫ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

1.1. “Улаанбаатар БҮК”ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Аудит, Эрсдэлийн Хороо (“Аудит, Эрсдэлийн Хороо” гэх)-ны Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналт, комплайнс, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн байдалд тавих хяналтыг энэхүү Журмаар зохицуулна.

2. Аудит, Эрсдэлийн Хорооны зорилго, чиг үүрэг

2.1. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих хорооны чиг үүрэг:

1) Компанийн удирдлага, хөндлөнгийн аудитортай санхүүгийн тайлан, түүнчлэн санхүүгийн тайлангийн ашигласан зарчмуудын үнэн зөв, хүлээн зөвшөөрөгдөх байдал, санхүүгийн тайланд чухал ач холбогдолтой тооцоолол, тайланд хийсэн томоохон залруулга зэргийг хэлэлцэх;

2) компанийн улирал, хагас жил, жилийн эцсийн санхүүгийн тайланд урьдчилсан дүгнэлт хийх;

3) аудитын явц, үр дүн, хараат бус байдлыг хадгалах, компанид ашиг сонирхлын зөрчилгүй байх талаар хөндлөнгийн аудиторын өгсөн мэдээллийг авч үзэх.

2. 2.Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцооны найдвартай, үр ашигтай байдлыг хангах хорооны чиг үүрэг:

1) шаардлагатай бол, гэхдээ жилд нэгээс доошгүй удаа компанийн дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр нөлөөг үнэлэх;

2) эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог үр дүнтэй ажиллуулах зохион байгуулалтын талаар зөвлөмж өгөх;

3/ дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцооны байдлын талаарх хөндлөнгийн болон дотоод аудиторуудын тайланг авч үзэх;

4) дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоотой холбоотой компанийн хөндлөнгийн болон дотоод аудиторуудын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих;

5) тогтвортой хөгжлийн салбарын эрсдэл, санхүүгийн бус мэдээлэл, тайлангийн чанарт хяналт тавих;

6) Компанийн удирдлагатай тогтмол уулзалт хийж, томоохон эрсдэлүүд, дотоод хяналтын асуудал, тэдгээрийг шийдвэрлэх компанийн холбогдох төлөвлөгөөтэй танилцах.

- 7) эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоо, дотоод үйл ажиллагааг зохион байгуулах зарчим, хандлагыг тодорхойлсон компанийн дотоод баримт бичгүүдийг батлах, хянан үзэх,
- 8) дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Компаниас боловсруулсан арга хэмжээний үр дүнд дүн шинжилгээ хийж, хэрэгжилтийн чанарыг үнэлэх;
- 9) улиралд дор хаяж нэг удаа Дотоод аудитор, компанийн эрсдэлийн ахлах менежертэй уулзалт хийх.

3. Гадаад аудитын хорооны чиг үүрэг:

- 1) Компанийн хөндлөнгийн аудиторыг томилох, өөрчлөх талаар Компанийн ТУЗ-д зөвлөмж хүргүүлэх;
- 2) хөндлөнгийн аудиторын урамшууллын хэмжээний талаар зөвлөмж бэлтгэх;
- 3) хөндлөнгийн аудиторуудын үзүүлж буй үйлчилгээг батлах, түүнчлэн хөндлөнгийн аудитороос компанид үзүүлж буй холбогдох бүх үйлчилгээний жагсаалтыг хөндлөнгийн аудитороос хүлээн авах, хөндлөнгийн аудитортай хэлэлцэх;
- 4) компанийн жилийн санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитортай байгуулах гэрээний (гэрээ) төслийн үндсэн нөхцөлийг батлах;
- 5) аудитын үр дүнгийн талаархи компанийн удирдлагын мэдээллийг багтаасан жилийн болон завсрын аудитын үр дүнг урьдчилсан байдлаар авч үзэх;
- 6) хөндлөнгийн аудитын үйл ажиллагааны үр нөлөөг үнэлэх;
- 7) хөндлөнгийн аудиторын хараат бус байдал, үр нөлөө, бодитой байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, хяналт тавих, шаардлагатай бол Төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөмж хүргүүлэх;

4. Дотоод аудитор/Аудит эрсдлийн хорооны ажлын алба/ хорооны чиг үүрэг:

- 1) Компанийн Дотоод аудиторын / Аудит эрсдлийн хорооны ажлын алба/ үйл ажиллагаанд хяналт тавих;
- 2) Аудит эрсдлийн хорооны ажлын албаны орон тоо, бүрэн эрхийн хугацаа, дарга, ажилтныг томилох, хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, түүнчлэн тэдгээрийн залгамжл халааны талаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд санал гаргах;
- 3) Компанийн ТУЗ-д цалин хөлсний хэмжээ, нөхцлийн талаар санал гаргах, урамшуулал тогтоох, ажлын албаны дарга, ажилтны үйл ажиллагааг үнэлэх;

3. Аудит, Эрсдэлийн Хорооны бүтэц, бүрэлдэхүүн

3.1. Аудит, Эрсдэлийн Хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Аудит, Эрсдэлийн Хорооны чиг үүргийг хэрэгжүүлэх 2-оос доошгүй дотоод аудитор, 1

комплайнсын мэргэжилтнээс бүрдсэн Аудит, эрсдэлийн хорооны ажлын албатай байна.

- 3.2. Аудит, Эрсдэлийн Хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүд байх ба Аудит, Эрсдэлийн Хорооны 2 хүртэлх гишүүн нь эдийн засаг, санхүүгийн ажлын туршлагатай байна.
- 3.3. ТУЗ-нь Аудит, Эрсдэлийн Хорооны гишүүд болон даргыг томилно.
- 3.4. Аудит, Эрсдэлийн Хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна
- 3.5. Аудит, Эрсдэлийн Хорооны санал болгосноор ТУЗ нь Аудит, Эрсдэлийн хорооны ажлын албаны гишүүдийг томилно.
- 3.6. Компанийн Гүйцэтгэх удирдлага Аудит, Эрсдэлийн Хорооны гишүүн байхыг хориглоно.
- 3.7. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Аудит, Эрсдэлийн Хорооны нарийн бичгийн дарга байна.
- 3.8. Аудит, Эрсдэлийн Хорооны нарийн бичгийн дарга нь Аудит, Эрсдэлийн Хорооны ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллана.

4. Аудит, Эрсдэлийн Хорооны хурал

- 4.1. Аудит, Эрсдэлийн Хороо нь жилд 4 хүртэлх удаа хуралдаж болох бөгөөд жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан нийтлэгдэхээс өмнө заавал хуралдсан байна.
- 4.2. Хурлын хуваарь болон хурлаар хэлэлцэх асуудлыг Аудит, Эрсдэлийн Хорооноос жил бүр батална.
- 4.3. Хурлын зарыг ажлын 5 хоногийн өмнө тараах бөгөөд хуралд биеэр болон телеконференцийн хэлбэрээр оролцож болно.
- 4.4. Шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн болон дотоод аудиторуудын саналаар хурлыг зарлан хуралдуулж болно. Энэ тохиолдолд 3.3 дахь заалт хамаарахгүй.
- 4.5. Аудит, Эрсдэлийн Хорооны хуралд ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн бусад гишүүд, Компанийн Гүйцэтгэх удирдлага, дотоод аудиторуудын төлөөлөл болон бусад этгээд Аудит, Эрсдэлийн Хорооны даргын зөвшөөрснөөр хорооны хуралд оролцож болно.
- 4.6. Аудит, Эрсдэлийн Хорооны хурал нь 2 гишүүний ирцтэйгээр хүчин төгөлдөр болно.
- 4.7. Хурлаас гарах бүх шийдвэрийг олонхийн саналаар батална. Санал тэнцсэн тохиолдолд Аудит, Эрсдэлийн Хорооны дарга шийдвэрлэх санал өгнө.
- 4.8. Компанийн нарийн бичгийн дарга нь Аудит, Эрсдэлийн Хорооны хурлын батлагдсан тэмдэглэлийг ТУЗ-ийн бүх гишүүд, дотоод, гадаад аудит болон гүйцэтгэх удирдлагад хүргэнэ. Тэмдэглэлд хурлаар хэлэлцсэн чухал санал, дүгнэлт, тохиролцсон асуудлыг багтаасан байна.

5. Аудит, Эрсдэлийн Хорооны Бүрэн эрх

- 5.1. Аудит, Эрсдэлийн Хорооны нь дор дурьдсан асуудлаар дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулах, шийдвэр гаргах бүрэн эрхтэй:
 - 5.1.1. Компаний Санхүүгийн тайлангийн явцыг хянах;
 - 5.1.2. Компаний үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Хорооны хурлаар хэлэлцэн, ТУЗ –ын хуралд оруулах
 - 5.1.3. Албан үүргийнхээ дагуу шалгалт явуулах;

- 5.1.4. Компаний үйл ажиллагаатай холбоотой бичмэл болон цахим баримт, мэдээлэл, материалыг Гүйцэтгэх удирдлагын гишүүд болон Компанийн холбогдох албад, ажилтнуудаас Аудитын Хорооны нарийн бичгийн даргаар уламжлуулан гаргуулан авах, хяналт шалгалт хийх, объектод саадгүй нэвтрэх, (**Аудит, Эрсдэлийн Хорооноос гаргасан шаардлагын дагуу Компанийн бүх ажилчид хамтран ажиллах үүрэгтэй**); /аудитын дүрмэнд заасны дагуу/
- 5.1.5. Шаардлагатай тохиолдолд ТУЗ-н зөвшөөрлөөр, Компаний зардлаар хөндлөнгийн хуулийн болон бусад хараат бус мэргэжлийн байгууллагын зөвлөлгөө авах, аутсорсинг, сосорсингийн үйлчилгээ авах, туршлагатай хөндлөнгийн байгууллагын оролцоог хангах, дүгнэлт гаргуулах
- 5.1.6. Хөндлөнгийн аудитын ажлын тайланг хүлээн авах, танилцах, гэрээт ажлын үр дүнг хэлэлцэх

6. Аудит, Эрсдэлийн Хорооны ажлын тайлан

- 6.1. Аудит, Эрсдэлийн Хорооны нь албан үүргийнхээ хүрээнд гүйцэтгэх чиг үүрэг, хариуцлагын дагуу хийсэн ажлаа жил бүр ТУЗ-д тайлагнаж, Компанийн жилийн ажлын тайлан болон Компанийн цахим хуудсанд тавигдах тайланд дүгнэлт бэлтгэнэ. Уг дүгнэлтэнд дараах зүйлсийг оруулна:
- 6.1.1. Аудит, Эрсдэлийн Хорооны гүйцэтгэх үүрэг болон явуулсан үйл ажиллагааны тойм;
- 6.1.2. Тайлант хугацаанд ажилласан Аудит, Эрсдэлийн Хорооны гишүүдийн нэр, мэргэжил;
- 6.1.3. Аудит, Эрсдэлийн Хорооны хурлын ирц.

7. Хариуцлага

7.1. Энэхүү аудит, эрсдэлийн хорооны журмыг зохих ёсоор хэрэгжүүлээгүйгээс Компанид аливаа хохирол учруулсан эрх бүхий албан тушаалтан Компаний хуулийн 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

7.2. Аудит эрсдэлийн хорооны журам болон бусад Компанийн дүрэм журмуудад заасан заалтуудыг зөрчсөн, өөрийн ажил үүргээ биелүүлэх явцдаа мөрдөж ажиллаагүй Компанийн аливаа ажилтан Компанийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, Ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу холбогдох хариуцлага хүлээнэ.

АУДИТ, ЭРСДЭЛИЙН ХОРОО